



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/89

Хэрлэн сум

Математикийн олимпиадыг зохион
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хууль 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын тэргүүний ажилтан Гомбын Өлзийхутагийн нэрэмжит Зүүн бүсийн математикийн олимпиадыг зохион байгуулах зардалд зориулж 6,540,000 (зургаан сая таван зуун дөчин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
 02 дугаар сарын 21-ны
 9/89 дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо					
№	Анги	Байр	Медаль	Мөнгөн шагнал	Нийт
1	7-р анги	I байр	Алт	200,000	450,000
		II байр	Мөнгө	150,000	
		III байр	Хүрэл	100,000	
2	8-р анги	I байр	Алт	200,000	450,000
		II байр	Мөнгө	150,000	
		III байр	Хүрэл	100,000	
3	9-р анги	I байр	Алт	200,000	450,000
		II байр	Мөнгө	150,000	
		III байр	Хүрэл	100,000	
4	10-р анги	I байр	Алт	200,000	450,000
		II байр	Мөнгө	150,000	
		III байр	Хүрэл	100,000	
5	11-р анги	I байр	Алт	200,000	450,000
		II байр	Мөнгө	150,000	
		III байр	Хүрэл	100,000	
6	12-р анги	I байр	Алт	200,000	450,000
		II байр	Мөнгө	150,000	
		III байр	Хүрэл	100,000	
7	Бага ангийн багш	I байр	Алт	500,000	950,000
		II байр	Мөнгө	300,000	
		III байр	Хүрэл	150,000	
8	Дунд ангийн багш	I байр	Алт	500,000	950,000
		II байр	Мөнгө	300,000	
		III байр	Хүрэл	150,000	
9	Уран бодолт				200,000
10	Гранпри				200,000
11	Түрүүлсэн багийн шагнал				1,000,000
12	Медаль				300,000
13	Оролцогчдод дурсгалын зүйл				240,000
Нийт					6,540,000